



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/148

Хэрлэн сум

Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын  
уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулахад  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 04 дүгээр, “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” 05 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын Хэнтий аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 онд Хамтран ажиллах гэрээний хүрээнд “Хэнтий аймгийн аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын бодлого, арга хэмжээ, хамтын ажиллагаа” сэдэвт аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулахад 7,950,000 (долоон сая есөн зуун тавин мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зарцуулах хөрөнгийн зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ





۲۵۲۹ ۳۰ ۲۲

اسق مصلحتون . بمصلحتي و بصلحتي  
 مصلحتي . بصلحتي و بصلحتي  
 مصلحتي و بصلحتي

[illegible]